



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 91

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 136 дугаар тогтоол, 2020 оны 111 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн тусгай хамгаалалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 ширхэг нийт 89,133,000.00 (наян есөн сая нэг зуун гучин гурав мянган) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг хавсралтад заасны дагуу ашиглах хугацаа, үнийг нийт 6,000,000.00 (зургаан сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанд тус тус балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга, хурандаа П.Батаа, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн захирал Н.Хүрэлбаатар, Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны дарга А.Энхзул нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Автомашины улсын дугаарыг улсын бүртгэл, татвар төлөгчөөс шилжүүлэн арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ

АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001300

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын

2021 оны 08 дугаар сарын 28 өдрийн

дугаар тогтоолын хавсралт

**ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ  
БАЛАНСААЙ БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон огноо	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шинэчлэн тогтоосон үнэ /төгрөг/	Ашиглах хугацаа	Шилжүүлэн авах хуулийн этгээдийн нэр
1	Ниссан максима, 1041 УНУ8 арал IN4BA1E77C830898	2006/2007	44,566,500.00	0.00	3,000,000.00	3	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
2	Ниссан максима, 0769 УНУ8 арал IN4BA41F97C827520	2006/2007	44,566,500.00	0.00	3,000,000.00	3	Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба
			89,133,000.00		6,000,000.00		
	<b>Нийт дүн</b>		(наян есөн сая нэг зуун гучин гурав мянга)		(зургаан сая)		